

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**
(2025 оны жилийн эцсийн байдлаар)

2026.01.08

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл, зорилго, арга зүй

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ыг үндэслэл болгов.

Иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, байгууллагын үйл ажиллагааг цахим хэлбэрээр нээлттэй ил тод, шуурхай байлгах, олон нийтийн хяналтыг бий болгож байгаа талаарх тайлангийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах зорилготой.

Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан ёсны цахим сайт болох <https://pcsp.gov.mn/>, төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим систем <https://umch.gov.mn/>, шилэн дансны <https://shilendans.gov.mn/organization/8324?ry=2025&group=117> сайт, төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас <https://www.gov.mn/mn/organization/pcsp>-д байршуулсан мэдээлэлд үндэслэн Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-д заасан аргачлалаар гүйцэтгэв.

Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт:

Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-д заасан 5 бүлгийн 71 шалгуур үзүүлэлтээр тайлагнаж мэдээлэхээс Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь 2025 оны жилийн эцсийн байдлаар өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дараах 5 бүлгийн 46 шалгуур үзүүлэлтээр тайлагнаж, 100 хувийн гүйцэтгэлтэйгээр холбогдох цахим хуудсанд байршуулж, мэдээлсэн байна.

- Нэг.Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал: 10 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт – 100.0 хувь;
- Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал: 6 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт – 100.0 хувь;
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал: 15 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт – 100.0 хувь;
- Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал: 2 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт – 100.0 хувь;
- Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал: 13 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт – 100.0 хувь буюу ерөнхий дундаж үнэлгээ 100.0 хувьтай байна.

Төсөв, санхүүгийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтээс 2 үзүүлэлт 2026 оны 1 дүгээр улиралд дүгнэлт тайлан гарахаар хүлээгдэж байгаа тул хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй төлөвөөр үнэлсэн.

Байгууллагын чиг үүрэгт хамааралгүй 10 шалгуур үзүүлэлтийг мөн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй төлөвөөр үнэлж, ерөнхий үнэлгээнд тооцоогүй.

НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХҮСНЭГТ

№	Нээлттэй мэдээлэл	Шалгуур үзүүлэлтийн оноо				Хэрэгжилтийн хувь
		МХБ	ХНБ	МБББ	ЭСТБ	
Нэг.Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал						
1.1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн	30	30	30	30	100%
1.2	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг	30	30	30	30	100%
1.3	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж	30	30	30	30	100%
1.4	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан	30	30	30	30	100%
1.5	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан	30	30	30	30	100%
1.6	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт	30	30	30	30	100%
1.7	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг	30	30	30	30	100%
1.8	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ	30	30	30	30	100%
1.9	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл	30	30	30	30	100%
1.10	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр	30	30	30	30	100%
Дундаж оноо, хувь						100%
Хоёр.Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал						

2.1	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл	30	30	30	30	100%
2.2	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам	30	30	30	30	100%
2.3	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм	30	30	30	30	100%
2.4	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам	30	30	30	30	100%
2.5	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ	30	30	30	30	100%
2.6	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам	30	30	30	30	100%
Дундаж оноо, хувь						100%
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал						
3.1	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл	30	30	30	30	100%
3.2	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан	30	30	30	30	100%
3.3	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	ХБ	ХБ	ХБ	ХБ	ХБ
3.4	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ	ХБ	ХБ	ХБ	ХБ	ХБ
3.5	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	30	30	30	30	100%
3.6	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	30	30	30	30	100%
3.7	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт	30	30	30	30	100%
3.8	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	ХБ	ХБ	ХБ	ХБ	ХБ
3.9	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл	30	30	30	30	100%
3.10	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй	30	30	30	30	100%

	оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан					
3.11	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт	ХБ	ХБ	ХБ	ХБ	ХБ
3.12	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл	ХБ	ХБ	ХБ	ХБ	ХБ
3.13	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн	ХБ	ХБ	ХБ	ХБ	ХБ
3.14	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан	ХБ	ХБ	ХБ	ХБ	ХБ
3.15	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцох эрхийг хязгаарласан этгээдийн жагсаалт	ХБ	ХБ	ХБ	ХБ	ХБ
Дундаж оноо, хувь						
Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал						
4.1	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл	30	30	30	30	100%
4.2	Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.	30	30	30	30	100%
Дундаж оноо, хувь						100%
Тав.Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал						
5.1	Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал	30	30	30	30	100%
5.2	Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт	ХБ	ХБ	ХБ	ХБ	ХБ
5.3	Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл	ХБ	ХБ	ХБ	ХБ	ХБ

5.4	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл	30	30	30	30	100%
5.5	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг	30	30	30	30	100%
5.6	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл	30	30	30	30	100%
5.8	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл	30	30	30	30	100%
5.11	Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт	ХБ	ХБ	ХБ	ХБ	ХБ
5.20	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт	ХБ	ХБ	ХБ	ХБ	ХБ
5.21	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан	30	30	30	30	100%
5.22	Албан тушаалтны Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл болон энэ хуулийн 8.6-д заасан тайлбар	30	30	30	30	100%
5.23	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг	30	30	30	30	100%

	сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлт					
5.24	Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэл	30	30	30	30	100%
5.25	Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл	30	30	30	30	100%
Дундаж оноо, хувь						100%
Үнэлгээний ерөнхий оноо, хувь						100%

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТГИЙН
ДАРГА:

Н.ГАНБОЛД

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
МЭРГЭЖИЛТЭН:

Д.ЦЭРЭНЛХАМ